



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Аэродромын албанд аэродромын засвар арчлалтын ажилд шаардлагатай будаг, будаг шингэлэгч, гэрэл ойлгогч, карбомид нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Д.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Энх-Амгалан	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	С.Чинзориг	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Х.Болор-Эрдэнэ	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Эрдэнэбаатар/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ДАРГА |  Л.БЯМБАСҮРЭН